



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 12 өдөр

Дугаар А/523

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 Тариалангийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээний ургац хураалтын ажлыг технологит хугацаанд саадгүй явуулах ажлыг зохион байгуулж, хяналт тавих чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсугай.


2. Ургац хураалтын ажлыг эрчимжүүлэх, хяналт тавих ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, гишүүдийн ажил үүргийн хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн ургац хураалт дуусах хүртэлх хугацаанд ажлын хэсгийг ажилуулж, сумдаас ирүүлсэн явцын мэдээний бодит байдалд хяналт тавих, ирүүлсэн санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Ажлын хэсгийн даргад үүрэг болгосугай.

4. Ургац хураалттай холбогдуулан ажлын хэсгийг байгуулан, хураалт дуусах хүртэлх ажил үүргийн хуваарийг баталж, хураалтыг технологит хугацаанд дуусгаж, балансаар тогтоогдсон ургацаа мал, амьтдаас хамгаалах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг тариалан бүхий сумдын Засаг дарга нарт даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Захирамж-2023

671 011168

Аймгийн Засаг даргын 2023 оны  
10 дугаар сарын 12-ны өдрийн А/523  
дүгээр захирамжийн 1 дүгээр хавсралт



## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:  
(Аймгийн Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга: (Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйлдвэрлэл, худалдаа  
үйлчилгээний албаны дарга)

Гишүүд:

- (Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)
- (Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)
- (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)
- (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
- (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)
- (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)
- (Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)
- (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга)
- (Аймгийн Онцгой байдлын газрын дарга)
- (Аймгийн Цагдаагийн газрын дарга)
- (Аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга)
- (Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)
- (Аймгийн Авто тээврийн төвийн дарга)
- (Аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга)
- (Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга)

— оОо —

Аймгийн Засаг даргын 2023 оны  
10 дугаар сарын 12 ны өдрийн А/523  
дүгээр захирамжийн 2 дугаар хавсралт

АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ

№	Штабын гишүүдийн албан тушаал	Ажил үүргийн хуваарь
1	(Засаг даргын орлогч)	Штабын гишүүдийг удирдлагаар хангах, штабын гишүүдийн хариуцсан ажилд хяналт тавих.
2	(Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга)	Сум орон нутгийг нэгдсэн удирдлагаар хангах, уялдуулан зохицуулах
3	(Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)	Эрчим хүч, шатахуун түлшээр тасралтгүй хангах, ургацыг малаас хамгаалах тухай Засгийн газрын тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих.
4	(Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)	Шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх.
5	(Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)	Ургац хураалтад ажиллах техник, хүн хүчний дэмжлэг үзүүлэх
6	(Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга)	Газар тариалан болон ургац хураалттай холбоотой хууль эрх зүйн асуудал
7	(Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)	Ургац хураалтад ажиллах техник, хүн хүч, шатахууны асуудал
8	(Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)	Газрын эзэмшилт, ашиглалт зориулалтын бус ашигласан тариалангийн талбайн асуудал
9	(Аймгийн Засаг даргын тамгын газрын Цэргийн штабын дарга)	Ургац хураалтад ажиллах техник, хүн хүчний дэмжлэг үзүүлэх
10	(Аймгийн Онцгой байдлын газрын дарга)	Шаардлагатай үед нэмэлт хүн хүчний асуудлыг шийдвэрлэх, гал түймрээс урьдчилан сэргийлэх
11	(Аймгийн Цагдаагийн газрын дарга)	Ургац хураалтын үеийн хэв журмыг сахиулах, тээврийн хэрэгсэлийн аюулгүй байдлыг хангуулах.
12	(Аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга)	Цаг уурын мэдээг тухай бүрд шуурхай хүргэх
13	(Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)	Ургац хураалтыг зам, гүүрийн засвар үйлчилгээг хангах.
14	(Аймгийн Авто тээврийн төвийн дарга)	Ургац тээвэрлэх техник, тоног төхөөрөмжийн асуудал хариуцах
15	(Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар)	Штабын дотоод ажил, технологи, мэргэжил арга зүйгээр хангах, явцын мэдээг авч, хянан тайлагнах,
16	(Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар)	Үр болон таворын улаан буудай, төмс, хүнсний ногооны стандарт хангуулах, шинжилгээнд хамруулах, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангуулах.
17	(Аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга)	Ургац хураалтад ажиллах хүн хүчний дэмжлэг үзүүлэх
18	(Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга)	Ургац хураалтад ажиллах хүн хүчний дэмжлэг үзүүлэх